



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01/26

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2, 13.1.3, Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2017-2018 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яам, түүний харьяа байгууллагуудын ажилтан, албан хаагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулж буй 5 төрөлт спортын тэмцээнд оролцох ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Зам, тээврийн салбарын аварга шалгаруулах 5 төрөлт тэмцээнд оролцоход шаардагдах зардлын төсвийг 2018 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор боловсруулж, батлуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Ё.Эрдэнэбат/-д даалгасугай.

3. Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Спорт, баяр ёслолын зардлаас батлагдсан төсвийн дагуу гарган зарцуулахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын  
2018 оны 13 дугаар сарын 14 -ны өдрийн  
18/126 дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ БОЛОН ТҮҮНИЙ ХАРЬЯА  
БАЙГУУЛЛАГУУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 5 ТӨРӨЛТ  
СПОРТЫН ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:	Ё.Эрдэнэбат	Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Пүрэвсүрэн	Хэвлэх цехийн хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Б.Ганхуяг	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Б.Энх-Амгалан	Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Д.Түвшинбаяр	Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
	О.Тэмүгэ	Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
	Т.Хулан	Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны захиргааны мэргэжилтэн
	Э.Батболд	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны мэдээллийн технологийн мэргэжилтэн
	Г.Мөнхтүвшин	Хэвлэх цехийн дарга
	Ч.Баяртөгс	Санхүү, эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч
	Г.Доржханд	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч